



СҮХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 49

Баруун-Урт

ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, Аймгийн ИТХ-ын 2013 оны ээлжит бус 4 дүгээр хуралдааны 6 дугаар тогтоолоор батлагдсан, "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Эрдэнэцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулиас Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 47 дугаар ангид шилжүүлэх үндсэн хөрөнгийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дээрх хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Орон нутгийн өмчийн алба / Ц.Нарантуяа/-д даалгасугай.

Гурав. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Ж.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Б.ГАНСҮХ

